



**НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 02 сарын 25 өдөр

Дугаар A/27

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах иж бүрэн
сургуульд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.1, 51.1.2; Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт; Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах тухай” А/88, “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд сургалт зохион байгуулах тухай” А/89 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-д бэлтгэх, оролцох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон харьяа эрүүл мэндийн байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх чадавхийг бэхжүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, нийслэлийн гамшгаас хамгаалах албадтай хамтын ажиллагааг сайжруулах, сургаж, дадлагажуулах зорилгоор нийслэлийн “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-д 2019 оны 04 дүгээр сарын 24,25,26-ны өдөр зохион байгуулалт, хариуцлага, сахилга батын өндөр түвшинд бэлтгэж оролцохыг Ажлын хэсэг /Л.Зэндмаа/-т даалгасугай.

3. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд заасан үүрэг чиглэл, өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын нийт бүрэлдэхүүн, харьяа эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч дарга /Л.Зэндмаа/, Гамшиг онцгой байдлын үеийн болон түргэн тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Ш.Тэгшбаяр/ нарт үүрэг болгосугай.

5. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн хүрээнд зохион байгуулагдах дадлага сургуульд, нэгдсэн төлөвлөгөөний дагуу бэлтгэл хангаж, оролцохыг харьяа байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

6. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн үед оролцогчид болон дадлага сургуульд оролцож буй иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг ханган, зохион байгуулж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /М.Мөнхдэлгэр/-т үүрэг болгосугай.

1150500048

7. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэлийг хангах, зохион байгуулахад шаардагдах 1315000 /нэг сая гурван зуун арван таван мянган төгрөг/-ийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Н.Баярхүү/-д зөвшөөрсүгэй.


8. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Л.Зэндмаа/-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 02 дугаар сарын 25 өдрийн
...1/27 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Л.Зэндмаа Орлогч дарга

Гишүүд:

Г.Баянжаргал Захиргаа, төлөвлөлт, хяналт-
шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

М.Мөнхдэлгэр Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

З.Отгонбаяр Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга


О.Энхзаяа Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

С.Ариунтуяа Статистик, мэдээллийн хэлтсийн дарга

Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нар

Нарийн бичиг:

Ш.Тэгшбаяр Гамшиг, онцгой байдлын үеийн болон
түргэн тусламжийн үйлчилгээний асуудал хариуцсан
мэргэжилтэн



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 07 дугаар сарын 16 өдрийн
174 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2019 ОНЫ “ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ТУХАЙ” А/88, “ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛИЙН ХҮРЭЭНД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ”
А/89 ДҮГЭЭР ЗАХИРАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Хэрэгжилтэнд хяналт тавих албан тушаалтан
Нэг. Бэлтгэл ажлыг хангах талаар:					
1	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгүүдэд ажиллах албан тушаалтныг томилгоожуулах, НОБГ-т хүргүүлэх	22/II	Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Г.Баянжаргал Хэлтсийн дарга	Л.Зэндмаа Орлогч дарга
2	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд бэлтгэж, оролцох, хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө гаргаж, даргын тушаалаар батлуулах	25/II-ны дотор	Г.Баянжаргал Хэлтсийн дарга Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Л.Зэндмаа Орлогч дарга	Л.Төмөрбаатар Газрын дарга
3	Шадар Сайдын 2018 оны “Заавар батлах тухай” 120 дугаар тушаалын дагуу Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, батлуулах	15/III	Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	М.Мөнхдэлгэр Хэлтсийн дарга Штабын гишүүд	Л.Зэндмаа Орлогч дарга
4	Нийслэлийн Эрүүл мэндийн албаны хүч хэрэгслийн тодотгох	15/III-ны дотор	Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Харьяа байгууллагын дарга нар	Л.Зэндмаа Орлогч дарга
5	Эрүүл мэндийн штабын бүрэлдэхүүн, харьяа	27/II	Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Нийслэлийн Онцгой байдлын газар	Л.Зэндмаа Орлогч дарга

	байгууллагын дарга нар сургалтанд хамрагдах					
6	Харьяа байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт, тодотголд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах	20/II-15/III	Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Харьяа байгууллагын дарга нар	Л.Зэндмаа Орлогч дарга	
7	Нэгдсэн жагсаалын бэлтгэлийг зохион байгуулах, тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах	25/III-24/IV	Г.Баянжаргал Хэлтсийн дарга	Л.Зэндмаа Орлогч дарга Штабын гишүүд	Л.Төмөрбаатар Газрын дарга	
8	Штабын гишүүдийг хээрийн ажлын хувцсаар хангах	1/IV-ний дотор	З.Отгонбаяр Хэлтсийн дарга	Л.Зэндмаа Орлогч дарга	Л.Төмөрбаатар Газрын дарга	
9	Штабын гишүүдийн хувийн бэлэн байдлыг хангуулах, ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргын 2011 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 8 дугаар захирамжийн талаар мэдээлэл хийх	10/IV-ний дотор	Г.Баянжаргал Хэлтсийн дарга Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Л.Зэндмаа Орлогч дарга Штабын гишүүд	Л.Төмөрбаатар Газрын дарга	
10	Холбоо зарлан мэдээлэл, холбоо зохион байгуулалт Штабын гишүүдийг “Яаралтай цуглар” дохиогоор ажиллах бэлтгэлийг хангах, сурган дадлагажуулах	10/IV-ний дотор	Г.Баянжаргал Хэлтсийн дарга	Л.Зэндмаа Орлогч дарга	Л.Төмөрбаатар Газрын дарга	
11	Даргын ажлын болон шийдвэрийн зургийг бэлтгэх, хэвлүүлэх	1/IV-ний дотор	Г.Баянжаргал Хэлтсийн дарга	О.Энхзаяа Хэлтсийн дарга	Л.Зэндмаа Орлогч дарга	
12	Эрүүл мэндийн албаны штабын байр бэлтгэх, тоног	20/IV-ний дотор	Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Л.Зэндмаа Орлогч дарга	Л.Төмөрбаатар Газрын дарга	

	төхөөрөмжийн бэлтгэл ажлыг хангах, штабын гишүүдийг мэдээллээр хангах					
13	Нүүлгэн шилжүүлэх, нүүн шилжих дадлага сургуулийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар харьяа Эрүүл мэндийн төвүүдэд арга зүйгээр хангаж, бэлтгэл ажлыг хангуулах, явцын хяналт хийх	10/IV-ний дотор	М.Мөнхдэлгэр Хэлтсийн дарга Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Харьяа байгууллагын дарга нар	Л.Зэндмаа Орлогч дарга	
14	Газар хөдлөлтийн гамшгийн үеийн дуурайлган үзүүлэх дадлага сургуульд оролцох талаар удирдлага, арга зүйгээр хангах, бэлтгэлийг хангуулах, явцын хяналт хийх	10/IV-ний дотор	Л.Зэндмаа Орлогч дарга Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Төвийн 6 дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга нар	Л.Төмөрбаатар Газрын дарга	
15	Сургуулийн үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулах, бэлтгэлийг хангуулах	15/IV-ний дотор	Л.Зэндмаа Орлогч дарга Ш.Тэгшбаяр мэргэжилтэн	Ц.Пүрэвдаш Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Харьяа байгууллагын дарга нар	Л.Төмөрбаатар Газрын дарга	
16	Нийслэлийн удирдах бүрэлдэхүүний сорилын арга хэмжээг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах	10/IV-ний дотор	Ш.Тэгшбаяр мэргэжилтэн Ц.Пүрэвдаш Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал	Нийслэлийн Онцгой байдлын газар	Л.Зэндмаа Орлогч дарга	
17	Сургалт сурталчилгааны ажлын хэсэгт ажиллах	Хуваарийн дагуу	О.Энхзаяа Хэлтсийн дарга	Нийслэлийн Онцгой байдлын газар	Л.Зэндмаа Орлогч дарга	
Хоёр. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн үед						
1	Штабын гишүүд “Яаралтай	24/IV	Л.Зэндмаа	Л.Төмөрбаатар	Сургуулийн	

	цуглар” дохиогоор цугларч, хээрийн хувцас, аранзны бэлэн байдлыг хангаж ирэх, Нэгдсэн жагсаалд жагсах		Штабын дарга	Албаны дарга	удирдагч
2	Танхимын команд штабын сургуульд бэлэн байдлыг хангаж, оролцох	24/IV	Л.Төмөрбаатар Албаны дарга	Нийслэлийн Онцгой байдлын газар	Сургуулийн удирдагч
3	Эрүүл мэндийн албаны штабыг үйл ажиллагаанд оруулах /холбогдох баримт, судалгаа, холбоо мэдээлэл, тоног төхөөрөмж/	24/IV-25/IV	М.Мөнхдэлгэр Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Л.Зэндмаа Штабын дарга	Сургуулийн удирдагч
4	Харьяа албадын штабын үйл ажиллагаанд хяналт тавьж, байнгын холбоотой ажиллах	24/IV-25/IV	М.Мөнхдэлгэр Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Л.Зэндмаа Штабын дарга	Л.Төмөрбаатар Албаны дарга
5	Иж бүрэн сургуулийн оролцогчид, дадлага сургуульд оролцож буй иргэдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, бэлэн байдлыг хангаж ажиллах	24/IV-26/IV	Л.Зэндмаа Штабын дарга	Харьяа алба, мэргэжлийн ангийн дарга нар	Л.Төмөрбаатар Албаны дарга
6	Нүүн шилжих, нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх	25/IV	М.Мөнхдэлгэр Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Л.Зэндмаа Штабын дарга Төвийн 6 дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга нар	Л.Төмөрбаатар Албаны дарга
7	Газар хөдлөлтийн гамшгийн үеийн дуурайлган үзүүлэх дадлага сургуульд оролцох	25/IV	М.Мөнхдэлгэр Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Л.Зэндмаа Штабын дарга Төвийн 6 дүүргийн Эрүүл мэндийн албаны дарга нар	Л.Төмөрбаатар Албаны дарга